



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 7/502

Номгон

“Эрүүл мэндийн салбарын нэн шаардлагатай”
мэргэжилтэн бэлтгэж, чадавхжуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, 11.1.9, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан Аймгийн 2023 оны Хөгжлийн төлөвлөгөөний Төрийн бүтээмжийг сайжруулах, албан хаагчдыг тогтвортой ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний 6.1.4-ийн задаргаа хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай мэргэжилтэн бэлтгэж, чадавхжуулахад хөрөнгө зарцуулсугай.

2. Дутагдалтай байгаа нэн шаардлагатай мэргэжлээр суралцах мэргэжлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Сургалтын төлбөрт шаардлагатай 32.000.000 (Гучин хоёр сая) төгрөгийг Аймгийн 2023 оны Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.


4. Эмч мэргэжилтнүүдийн суралцах сургуультай гэрээ хийж, сургалтын чанарт анхаарч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т, эзэмшсэн мэргэжлээрээ орон нутагтаа үр дүнтэй, тогтвор суурьшилтай ажиллахыг сургалтад хамрагдах эмч мэргэжилтнүүдэд тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642311347

Аймгийн Засаг даргын ... оны ... дүгээр сарын
 29-ны өдрийн ... дугаар захирамжийн
 хавсралт



НЭН ШААРДЛАГАТАЙ МЭРГЭЖЛЭЭР СУРГАЖ ЧАДАВХЖУУЛАХ
 МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТ

№	Суралцах чиглэл	Сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтний тоо	Сургалтын төлбөр	Хөнгөлөлтийн дүн	Хөнгөлөлт нийт дүн	Тайлбар
1	2	3	4	5	6	7
Эрүүл мэндийн засаглал, удирдлага						
1	Анхан шатны эрүүл мэндийн удирдлага	8	362.500	2.900.000	2.900.000	Анхан шатны эмнэлгүүдийн удирдлагыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академид Удирдахуйн ухааны чиглэлээр сургаж чадавхжуулах шаардлагатай.
2	Эрүүл мэндийн бодлого, удирдлага	1	7.656.000	2.000.000	2.000.000	Бодлогын түвшний мэргэжилтнийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академид сургахад дэмжлэг үзүүлэх
Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ						
3	Талбарын тархвар судлал	1	768.000	1.000.000	1.000.000	Нийгмийн эрүүл мэндийн төвд мэргэшсэн талбарын тархвар судлаач нэн шаардлагатай.
4	Нийгмийн эрүүл мэндийн судлаач, эрүүл ахуйч	1	3.300.000	1.000.000	1.000.000	Нийгмийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан мэргэжилтэй албан хаагчдыг эрүүл мэнд судлаачаар бэлтгэх зорилготой.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ						
5	Анатомийн эмгэг судлал	1	800.000	3.000.000	3.000.000	Анатомийн эмгэг судлалын үндсэн мэргэжлийн эмч дутагдалтай байна.
6	Эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдал	1	384.000	1.000.000	1.000.000	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэст мэргэшсэн эмч мэргэжилтэн дутмаг байгаа нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тавих хяналт бодлогын түвшинд алдагдах нөхцөл үүссэн.
7	Сувилагч	7	2.500.000	1.250.000	8.750.000	2022 оноос орон нутагт бодлогоор сувилагч бэлтгэж байна. Аймгийн бодлогын баримт бичгүүдэд уг заалтууд тусгагдсан учир хэрэгжилтийг хангах шаардлагатай.
8	Бага эмч	10	2.750.000	1.225.000	12.250.000	Сүүлийн жилүүдэд Анагаахын их, дээд сургуулиуд бага эмч бэлтгэхгүй байна. Аймгийн хэмжээнд 14 багийн эмч дутагдалтай.
9	Нийт дүн				31.900.000	

.....оОо.....